



**ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭСРЭГ БҮХ ТӨРЛИЙН ЯЛГАВАРЛАН  
ГАДУУРХАЛТЫГ УСТГАХ ТУХАЙ КОНВЕНЦИЙН ХОРООНД ИЛГЭЭСЭН  
СҮҮДЭР ИЛТГЭЛ**

**УУЛ УУРХАЙ, ГАДААДЫН ШУУД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ БОЛОН ОЛОН  
УЛСЫН САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН БОДЛОГО  
ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРҮҮЛ МЭНДЭД СӨРГӨӨР НӨЛӨӨЛЖ БУЙ ТУХАЙ  
МОНГОЛ УЛСЫН ИЛТГЭЛД ДУРДААГҮЙ БАЙНА**

**6 ДУГААР САРЫН 15, 2020**

## Хураангуй

Энэхүү сүүдэр илтгэл нь Монгол улсын засгийн газар ЭЯГБХУТ Конвенцээр хүлээсэн үүрэг амлалтаа хэрхэн биелүүлж буйг авч хэлэлцэхэд хувь нэмэр оруулах үүднээс, ИНБ-уудын илтгэлүүдэд өмнө нь дурдагдаагүй асуудлыг Конвенцийн хорооны анхааралд хүргэхийг зорьж байна.

Монгол улсын эмэгтэйчүүд олноороо ажилладаг хөдөө аж ахуй (тэр дундаа мал аж ахуй) болон хөнгөн үйлдвэрлэлийн салбарт түшиглэсэн эдийн засгаас эрэгтэй ажиллах хүчин давамгайлсан уул уурхайн салбарт тулгуурласан эдийн засаг руу шилжсэн нь, мөн ийнхүү шилжихдээ “шок эмчилгээ” хэмээгдэх арга хэмжээнүүдийг авсан нь хэд хэдэн том үр дагавар авчирсан. Эдгээр арга хэмжээг **нийгэм, жендэр, эрүүл мэндийн аливаа үнэлгээгүйгээр** хэрэгжүүлсэн. Монголын засгийн газар олон улсын үндэстэн дамнасан корпорациудтай 30 жилийн турш (60+ жилээр сунгах эрхтэй) олборлолтын мега төслүүдийн гэрээ байгуулахдаа **эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ** хийлгэх болзлыг гэрээнд тусгахаас цааргалж ирсэн. Өнөөдрийг хүртэл Монголын засгийн газар охид, эмэгтэйчүүдийн эрүүл мэнд, тэр дундаа нөхөн үржихүйн эрүүл мэнд, аюулгүй байдалд уур уухайн үйл ажиллагаанаас үзүүлэх нөлөөллийн үнэлгээг хийхийг шаардахгүй байна.

Бид ганц уул уурхайн салбарт шингээх гадаадын шууд хөрөнгө оруулалтаас ихээхэн хамааралтай эдийн засгийн жендэрт үзүүлэх нөлөөлөл үндэсний хэмжээнд ямар байгаад анхаарал хандуулахыг хүсч байна. Монгол улс нэг зах зээл бөгөөд өсөлт-хямралын цикл бүхий дэлхийн эрдэс баялгийн зах зээл дэх үнийн хэлбэлзлээс хэт хамааралд ороод зогсохгүй хямралын үеийг даван туулахын тулд Олон улсын валютын сан (ОУВС)-ийн бодлогын болзолтот тусламжийн зээлээс давхар хамааралд орсон.

Бүх салбарыг, тэр дундаа эрүүл мэндийн салбарыг, уул уурхайг дэмжихэд чиглүүлж ирсэн Монгол дахь неолиберал бодлого нь эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийн жендэрийн тэгш байдлыг алдагдуулж, эмэгтэйчүүдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байна. Үүнийг бид улсын эрүүл мэндийн үйлчилгээний байгууллагууд болон **олон улсын санхүүгийн байгууллагуудын дэмжлэгээр байгуулагдсан хувийн эрүүл мэндийн үйлчилгээний байгууллагуудын** төлөв байдлыг харьцуулах замаар харуулах болно.

Монгол улсад 1990-ээд оноос хойш хэд хэдэн бүтцийн өөрчлөлтийг хийж, улсын салбарыг хумиж, эдийн засгийг дэлхийн санхүүгийн нөлөөнд өртөмтхий болгосон. Эдгээр өөрчлөн байгуулалттай зэрэгцүүлэн эмэгтэйчүүдэд онцгой хүндээр тусах “бүсээ чангалах” бодлого баримталсан нь эмэгтэйчүүдийн нийгэм дэх байр суурийг ихээхэн сулруулсан. Улмаар өнөөгийн байдлаар хамгийн бага цалинтай ажил бөгөөд үнэлгээгүй хөдөлмөр эрхлэгсдийн; байнгын санхүүгийн хомсдолтой улсын салбарт ажиллагсдын; мөн боловсрол, эрүүл мэнд зэрэг улсын байгууллагуудын үйлчилгээнээс хамгийн их хамааралтай хүмүүсийн дийлэнх нь эмэгтэйчүүд байна.

Бүтцийн өөрчлөлтүүд хэрэгжүүлэхээс өмнө Монголын эмэгтэйчүүдийн тэгш эрх, боловсролын түвшин Азийн бусад орнынхоос илүү өндөр байсан.<sup>1</sup> Шилжилт нь эмэгтэйчүүдийн байр суурь, эдийн засгийн баталгаатай байдал, нөхөн үржихүйн эрүүл мэнд болон нийгэм, улс төрийн оролцоог сулруулсан. “Бодлого тодорхойлдог байгууллага, үйл явц дахь эмэгтэйчүүдийн нөлөө шилжилтийн өмнөх түвшнээс буурсан. Шилжилтийн нэг үр дагавар бол эмэгтэйчүүдийн, ялангуяа хөдөө орон нутгийн ба нүүдэлчин эмэгтэйчүүдийн ажлын ачааллыг нэмэгдүүлсэн явдал мөн. Хувьчлалаар хөрөнгийн эзэмшил эрэгтэйчүүдийн гарт төвлөрсөн тул

---

<sup>1</sup> Robinson, B. and Solongo, A. (2000) The Gender Dimension of Economic Transition in Mongolia. In F. Nixon, B. Suvd, P. Luvsandorj, B. Walters (eds). The Mongolian Economy: A Manual of Applied Economics for a Country in Transition. Edward Elgar Publishing Ltd. 2000. pp. 231-255.

эмэгтэйчүүдийн зээл авах, улмаар бичил аж ахуй болон хувиараа хөдөлмөр эрхлэх боломж хомс байж ирсэн (2000:49).”<sup>2</sup>

Дэлхийн банкны групп (ДБГ) 1992, 1995 онуудаас эхлэн уул уурхайн салбарын эрх зүйн шинэчлэлийг дэмжиж ирсэн боловч байгаль орчны үнэлгээний (БОУ) тухай хуулийг уул уурхайн үйл ажиллагаанд ашигладаг цианид, мөнгөн ус зэрэг химийн бодисын хяналтгүй хэрэглээ нийтийн эрүүл мэндэд асар их хохирол учруулах нь ихсэж, нийтийг цочроосон хэд хэдэн эмгэнэлт тохиолдол гарсны дараагаар л, дөнгөж 2012 онд дэмжсэн. Ханбогд болон Гурвантэс суман дахь Оюу толгойн зэс-алтны ба Саут Гоби Сэндс зэргийн нүүрсний уурхай, мөн Улаанбадрах сум дахь АРЕВА-гийн ураны уурхайн орчимд амьдарч буй малчид нийгэм, соёл, эрүүл мэнд, жендэрийн сөрөг нөлөөллийг биеэрээ амсаж ирсэн бөгөөд түнш ТББ-уудаараа дамжуулан үндэсний болон олон улсын түвшинд эдгээр асуудлыг таниулж ирсэн. Уул уурхайн нөлөөлөлд өртсөн нутгийн иргэд эрүүл мэндийг нь хөнөөж буй тухай мэдэгдэл шаардлагуудад Монгол улсын засгийн газар зохисгүй хариу өгч иргэдийн баримт нотолгоог үл тоомсорлож, үгүйсгэж, мөн уул уурхайн сөрөг нөлөөллийг үнэлж, баримтжуулж, хязгаарлах хамтын ажиллагаанаас татгалзаж, цааргалж ирсэн.

Энэ илтгэл нь уул уурхайн улмаас хүмүүсийн эрүүл мэндэд, ялангуяа эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэндэд учирч буй сөрөг үр дагаврын тухай, уул уурхайн нөлөөлөлд өртсөн Монголын говь нутгийн иргэдийн өмнөөс ЭЯГБХУТ Конвенцийн хороонд хүргүүлж буй анхны илтгэл болно.

### **Макро эдийн засгийн бодлого ба хөрөнгө оруулалтын гэрээнүүд**

Дипломат шахалт болон ОУВС, ДБГ болон АХБ зэргийн бодлогын болзолтот зээлийн хөрөнгөөр Монголын хөгжлийн замыг нь уул уурхай болон уул уурхайг дэмжих салбаруудыг хөгжүүлэхэд голлон чиглүүлж ирсэн. ОУВС-ийн 2017 оны мэдээллийн дагуу, уул уурхайн орлого нь Монголын экспортын 90%-ийг эзэлж байна.<sup>3</sup> Монголын зэс, алтны томоохон уурхай болох Оюу толгой нь гадаадын шууд хөрөнгө оруулалтын дийлэнхийг татсан бөгөөд Монголын ДНБ-ний 30%-ийг эзлэх төлөвтэй байна. Хөрөнгө оруулалтын гэрээний хэлэлцээрт холбогдох хоёр компани болох Айвэнхоу Майнз (Оюу Толгой Ресурсээ), Рио Тинтоогоос гадна хэд хэдэн гадны дипломат баг оролцсон нь байгалийн баялгийн хэлэлцээр дэх дипломат шахалтын (resource diplomacy) тод жишээ юм.

Уул уурхайгаас хамааралтай байдал нь Монгол улсыг корпорациудын ашиг сонирхолд үйлчилсэн хууль гаргах, мөн Хөрөнгө оруулагч засгийн газрын маргаан таслах олон улсын механизм (ISDS)-ын улсын бодлогын ардчилсан орон зайг нь хумисан заалтуудыг хүлээж авахад хүргэсэн.<sup>4</sup> Үүний үр дагавар нь татварын ухранги (regressive taxation) бодлого, ОУВС-ийн зээлээс хамааралтай байдал, их хэмжээний гадаад өр, мөн байгаль орчин ба нийгмийг хамгаалах зохицуулалт хийх ородлогуудыг олон улсын маргаан таслах механизмыг ашиглан хазаарлах нөхцөл бүрдүүлсэн зэрэг юм. Уул уурхай, корпорациудын сонирхолд хөтлөгдсөн энэ бодлогын улсын төсөвт учруулсан хөнөөл нь жендэрийн ялгаатай нөлөөлөлтэй байж ирснийг дор дэлгэрүүлэх болно.

Ил уурхайгаасаа олборлож, мөн гүний уурхай барьж буй Оюу Толгой төсөл нь анхнаасаа нийгэм, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн хувьд маргаантай байсан. Байгаль орчны үнэлгээнүүд нь хуучирсан (2012) бөгөөд жендэрийн нөлөөллийн дүн шинжилгээ хийгдээгүй.

<sup>2</sup> Ibid p. 323

<sup>3</sup> IMF 2017, pg. 16: <https://www.imf.org/en/Publications/CR/Issues/2017/05/31/Mongolia-2017-Article-IV-Consultation-and-Request-for-an-Extended-Arrangement-Under-the-44954> (December 7, 2018).

<sup>4</sup> <https://www.somo.nl/undermining-mongolia/> (June 10, 2020)

Төслийн 2015 онд хийгдсэн Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд ч, аудитуудад нь ч жендэрийн нөлөөллийн дүн шинжилгээ байхгүй. Мега төслийн хэрэгжилтийн нөлөөлөл – нутгийн иргэд газаргүй болох, амьжиргааны эх үүсвэрээ алдах, биологийн төрөл зүйл устгах, нийгэм болон түүх соёлын дурсгал ба байгалийн нөөц баялагт хөнөөл учруулах гэх зэрэг үр дагаврууд - хэзээд жендэрийн ялгаатай тусдаг. Уул уурхайн үйл ажиллагаа охид, эмэгтэйчүүдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд шууд нөлөөлдөг.

Эмэгтэйчүүдийн Эдийн Засгийн Эрхмэдэлжилтийн асуудлаарх НҮБ-ын Дээд хэмжээний уулзалтаас 2017 онд “Макро эдийн засгийн бодлогууд эмэгтэйчүүдийн эдийн засгийн эрхмэдэлжилтийн ерөнхий орчныг тодорхойлдог тул жендэрийн тэгш эрхийг хангахад чухал үүрэгтэй”<sup>5</sup> гэж дүгнэсэн. Бид энэ дүгнэлтийн дагуу, Конвенцийн 7, 8, 10, 11, 12, 13 болон 14-р зүйлүүдтэй холбогдуулан, уул уурхайн салбарт төвлөрсөн гадаадын шууд хөрөнгө оруулалтаас хэт хамааралтай Монгол улсын эдийн засгийн нөхцөл байдалд анхаарал хандуулахыг хүсч байна.

Олон улсын хөрөнгө оруулалтын болон татварын гэрээ хэлэлцээний хүрээнд хийгдсэн Оюу Толгойн хөрөнгө оруулалтын гэрээний санхүүгийн тогтвортой байдлыг хангах, гомдол гаргах, маргаан таслахтай холбоотой заалтууд нь корпорацийн эрх ашгийг хамгаалж, компанид Засгийн газрыг сүрдүүлэх боломж олгосон. Энэ боломжийг Рио Тинто 2020 оны 2 дугаар сард 155 сая ам. долларын татвар нэмэх хуулийн төслийг эсэргүүцэхэд ашигласан. Энэ нь татварын диваажингуудыг ашиглан төлөхөөс зайлсхийсэн 230 сая ам. долларын татварын хэмжээнээс нь бага тоо юм.<sup>6</sup> Хөрөнгө оруулалтын маргааныг таслах ийм механизм зардал ихтэй бөгөөд Монголын иргэдийн нийтлэг ашиг сонирхолд нийцсэн шийдвэр гаргах магадлал багатайгаас гадна иргэдийнхээ нийтлэг ашиг сонирхлын төлөө хууль тогтоох Монгол улсын төр, засгийн чадамжийг нь сулруулж байна. Хөрөнгө оруулалтын хамгаалалт нь МУ-ын Засгийн газрыг татварын хуулиа өөрчлөх болон нийгэм, байгаль орчноо хамгаалах хуулийн зохицуулалт хийхэд нь саад учруулж байна.

Оюу Толгойн далд уурхайн санхүүжилтийн нүсэр бүтцэд Олон улсын санхүүгийн корпораци (ОУСК) болон Европын сэргээн босголт, хөгжлийн банк (ЕСБХБ) зэрэг засгийн газар хоорондын буюу олон улсын нийтийн санхүүгийн байгууллагууд голлох үүрэг гүйцэтгэж байгаа. Монголын 34 хувийг хувийн корпорациуд давамгайлсан хувьцаа эзэмшигчид бөгөөд төслийн менежер Рио Тинтоогоос авсан зээлээр, уурхайн ногдол ашгаас төлөгдөх болзолтойгоор авсан. Улсыг их хэмжээний өрөнд оруулж, засгийн газрын эрх мэдлийг хязгаарлахад хүргэсэн энэ төслийн орлого маш чамлахаар, сөрөг шахам үзүүлэлттэй байж ирсэн. Гадаадын хөрөнгө оруулагчдыг татах зорилгоор Монгол улсаас олгосон хөнгөлөлтүүд нь тогтвортой хөгжил, жендэрийн тэгш эрхийг дэмжихэд шардлагатай бодлогын орон зайг хааж байна.

Татвар төлөхөөс бултах явдал болон татварын ухранги (regressive taxation) бодлогоос улбаалсан улсын орлого алдалт, түүнийг даган улсын төсвийн зарлага буурсан нь жендэрийн тэгш эрхийг ахиулах хөтөлбөрүүдэд сөргөөр нөлөөлж байна. Гадаад өр зээл ба хүний эрхийн асуудлаарх НҮБ-ын Тусгай илтгэгчийн Ерөнхий Ассамблейд тавьсан 2018 оны илтгэлд цохон тэмдэглэсэнээр,<sup>7</sup> татварын орлого буурч, засгийн газрууд наад захын хэрэгцээтэй үйлчилгээнүүдэд зориулах төсвөө танахад эмэгтэйчүүдийн эрх хамгийн их хөндөгддөг. Нийтийн эрүүл мэнд, настайчууд болон хүүхдүүдэд чиглэсэн зэрэг эмэгтэйчүүдийн хөдөлмөр, тэр дундаа нилээд хэсэг нь үнэлгээ багатай хөдөлмөр зонхилдог, улсаас үзүүлдэг нийтийн үйлчилгээнүүдийг бэхжүүлэхэд татварын орлого чухал үүрэгтэй.

<sup>5</sup> UN High Level Panel on Women’s Economic Empowerment, *Taking action for transformational change on women’s economic empowerment*, 2017, p. 3.

<sup>6</sup> <https://www.somo.nl/riotinto-taxschemes-mongolia/> (June 10, 2020)

<sup>7</sup> UN Independent Expert on Foreign Debt, *Impacts of economic reforms and austerity measures on women’s human rights*, OHCHR, A/73/179, 2018.

“Цаашилбал, уул уурхайд нэрвэгдсэн нутгийн эмэгтэйчүүд уурхайн үйл ажиллагаанаас улблаатай байгаль орчны сүйрлийн улмаас амжиргааны эх үүсвэр, гэр орон, хоол хүнс, усны эх үүсвэр зэрэгээ алддаг. Иргэдийн эрх ашиг, сайн сайхан байдлыг хамгаалах үүрэгтэй засгийн газрууд байгалийн нөөц баялгийг ашиглаж буй уул уурхайн корпорациудаас тийм бага хэмжээний орлого хурааж, харин татварын орлого бүрдүүлэх дарамтын дийлэнхийг нь НӨАТ зэрэг тэгш бус байдлыг даамжруулдаг ухранги татвараар дамжуулан эмэгтэйчүүд болон ажил эрхэлж буй ядуусын нуруун дээр тохож байгааг нь хүлээн зөвшөөрөх боломжгүй юм.”<sup>8</sup> хэмээн Азийн ард түмнүүдийн өр ба хөгжил хөдөлгөөний судалгаанд дүгнэсэн байдаг.

Иймд бид дараах арга хэмжээнүүдийг зөвлөж байна:

- Цаашид хийгдэх бүх хөрөнгө оруулалтын гэрээг санхүүгийн амралт олгох, санхүүгийн тогтвортой байдлыг хангах, Хөрөнгө оруулагч засгийн газрын маргаан таслах олон улсын механизм ашиглах (ISDS) зэрэг заалтгүй оруулахгүй байх;
- Бүх томоохон төслийг батлахаас өмнө жендэр, эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээг хараат бус шинжээчдээр хийлгэх.<sup>9</sup>

Мөн АкшинЭйд-ын дараах зөвлөмжүүдийг дэмжиж хэрэгжүүлэхийг уриалж байна:

- "ОУВС болон Монгол улсын засгийн газар нь татварын болон бусад бодлогын зөвлөмжүүд нь эмэгтэйчүүдийн ялгаатай бүлгүүдэд үзүүлэх нөлөөлөл, шаардлагатай арга хэмжээнүүдийг тодорхойлох баримт нотолгоонд тулгуурлан, цогц аргачлал ашиглан, эмэгтэйчүүдийн эрхийг дэмжих макро эдийн засгийн орчныг бүрдүүлэх шаардлагатай.
- НӨАТ болон албан бус эдийн засагт ногдуулж буй шууд бус татваруудын ухранги нөлөөллийг аль болох багасгаж, татвар төлөх хамгийн их чадамжтай бүлгүүдээс татвар хураан, хөрөнгө баялгийг үр дүнтэйгээр дахин хуваарилж чадахуйц, жендэрийн шударга ёсонд нийцэхүйц дэвшилтэт шатлалт татварын бодлого хэрэгжүүлэх шаардлагатай.”<sup>10</sup>

2017 онд ОУВС 1990 оноос хойшхи 6 дахь удаагийн “тусламжийн” (bail-out) хэмээх барьцаа зээлээ олгосноор<sup>11</sup> Монгол улсын гадаад өрийг 11.2 тэрбум ам. долларт хүргэсэн ба энэ нь Монголын ДНБ-ийг хоёр нугалсантай тэнцэх дүн юм.<sup>12</sup> Зээлийн болзлууд нь цалин царцаах, хувь хүний албан татварын хэмжээг нэмэгдүүлэх<sup>13</sup> зэрэг “бүсээ чангалах” арга хэмжээ бүхий төсвийн

<sup>8</sup> <https://apmdd.org/campaigns/global-public-finance/tax-justice/women-make-noise-for-tax-justice> (May 13, 2020).

<sup>9</sup> Олборлох салбарын жендэрийн нөлөөллийн дүн шинжилгээг хэрхэн хийх тодорхой аргачлалыг эндээс харж болно:

<https://oxfamlibrary.openrepository.com/bitstream/handle/10546/620776/bp-gender-extractives-corporate-agenda-010516-en.pdf?sequence=1&isAllowed=y>. (June 10, 2020)

<sup>10</sup> ActionAid 2018, Short-Changed: How the IMF's Tax Policies Are Failing Women.

[https://actionaid.org/sites/default/files/short-changed\\_final.pdf](https://actionaid.org/sites/default/files/short-changed_final.pdf) (June 10, 2020).

<sup>11</sup> International Monetary Fund website, 2017, at <https://www.imf.org/en/News/Articles/2017/05/24/17193-imf-executiveboard-approves-financial-arrangement-for-mongolia>, see also Bloomberg, 2017, at <https://www.bloomberg.com/news/articles/2017-02-19/imf-to-loan-mongolia-440-million-as-part-of-5-5b-bailout> (June 12, 2017).

<sup>12</sup> Mongol bank, Mongolia's Gross External Debt Position at

[https://www.mongolbank.mn/eng/liststatistic.aspx?id=4\\_3](https://www.mongolbank.mn/eng/liststatistic.aspx?id=4_3); Financial Times, Mongolia: living from loan to loan, September 12, 2016 at <https://www.ft.com/content/4055d944-78cd-11e6-a0c6-39e2633162d5>; Focus Economics at <https://www.focus-economics.com/country-indicator/mongolia/externaldebt>;

<https://www.gfmag.com/global-data/country-data/mongolia-gdp-country-report> (August 2017).

<sup>13</sup> Bloomberg, 19 April 2017, at <https://www.bloomberg.com/news/articles/2017-04-19/mongolia-clears-hurdles-needed-for-5-billion-imf-led-bailout> (August 8, 2017).

шинэчлэлийг хамарсан.<sup>14</sup> 2017 оны хөтөлбөрийн хамгийн их маргаантай болзол нь хүүхэд бүрт олгодог байсан мөнгийг танаж зөвхөн хамгийн ядуу өрхүүдийн 60 хувьд олгох болзол байв.<sup>15</sup> Болзолтот хөтөлбөрт уул уурхайн корпорациудын ашиг сонирхол шууд нөлөөлсөн. Тухайлбал, банкны тухай хуулийн төслийн зарим заалт компанийх нь ашиг сонирхолд нийцэхгүй байна гэж Рио Тинто гомдол гаргахад ОУВС МУ-ын Засгийн газартай олгохоор нэгэнт тохирсон зээлээ хойшлуулах шийдвэр гаргаж, 3 өдрийн дараа Монгол улс дээрх хуулийн төслийг буцаан татсаны дараагаар зээлээ олгосон.<sup>16</sup>

Конвенцийн өмнөтгөлд “гишүүн орнуудын дотоод үйл хэрэгт гаднаас оролцох явдлыг халах нь эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд эрхээ бүрэн эдлэхэд зайлшгүй шаардлагатай нөхцөл юм” гэж дурдсныг санан, энэхүү зарчмыг олон улсын санхүүгийн байгууллагууд, тухайлбал ОУВС-д хамааруулах ёстой гэж үзнэ.

БреттонВүүдс төслөөс 2019 онд хийсэн ОУВС ба жендэрийн тэгш эрхийн тухай дүн шинжилгээнд тайлбарлснаар, ОУВС-аас санал болгож ирсэн макро эдийн засгийн бүх бодлогод хөдөлмөрийн зохицуулалтын уян бодлого, хувьчлал, ухранги татвар, чөлөөт худалдааг дэмжих, мөн нийгмийн хамгаалал, тэтгэврийн тогтолцоог сулруулах зэрэг жендэрийн сөрөг нөлөөлөлтэй арга хэмжээг тогтмол хамруулж ирсэн. Түүнчлэн, эдгээр арга хэмжээний түмэн нөлөөлөл нь хоорондоо огтлолцож, бие биенийхээ сөрөг үр дагаврыг улам даамжруулдаг тул бодлогоо ухаалгаар тодорхойлоход шинэчлэлийн хөтөлбөр нь бүхэлдээ жендэрийн ямар нөлөөлөлтэй байгааг судлах шаардлагатай байна.<sup>17</sup> гэж дүгнэсэн байдаг.

Байгалийн нөөц ихтэй Монгол шиг улс орнууд хамтран, олон улсын санхүүгийн байгууллагууд, ялангуяа Дэлхийн банк, ОУВС, АХБ, ЕСБХБ-наас улс орнуудын хяналт, хариуцлагын тогтолцоог сулруулах болзол тавьдаг явдлаа зогсоохыг шаардах хэрэгтэй гэж бид зөвлөж байна.

## **УУЛ УУРХАЙ БА ЭРҮҮЛ МЭНД**

### **Уул уурхайн нөлөөлөлд өртсөн нутаг дахь эх, хүүхдийн эрүүл мэндийн байдал**

Уул уурхайгаас үүдсэн эрүүл мэндийн асуудлууд 1990-ээд оны сүүлээр “Алт-1” хөтөлбөрийн уршгаар гарч эхэлсэн. Энэ хөтөлбөр хүний эрүүл мэндэд ихээхэн хор уршиг учруулсан ч үүнийгээ Засгийн газар одоо хүртэл хүлээн зөвшөөрөөгүй байгаа. 2018 онд Засгийн газар, төслийн сөрөг үр дагаврыг тооцоолж, хор хөнөөлийг багасгах арга хэмжээ тодорхойлоход чиглэсэн эрүүл мэндийн нөлөөллийн ямар нэгэн урьдчилсан үнэлгээ, төслийн дараах шинжлэх ухааны судалгаа хийлгүйгээр “Алт-1” хөтөлбөрийг хэрэгжүүлсэн Заамар суманд “Алт-2” хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн.<sup>18</sup>

---

<sup>14</sup> ОУВС-ийн болзлуудын тухай, мөн Монголд тавьж ирсэн болзлуудын дүн шинжилгээг эндээс харж болно: Brunswijk, G. (2018) Unhealthy Conditions, <https://eurodad.org/files/pdf/1546978.pdf> (December 17 2018).

<sup>15</sup> <https://www.developmentpathways.co.uk/blog/mongolia-kyrgyzsg-child-benefits/> and <https://www.brettonwoodsproject.org/2018/03/pro-poor-anti-poor-world-bank-imfs-approach-social-protection/>

<sup>16</sup> Edwards, T. May 5, 2017, <https://www.reuters.com/article/us-mongolia-imf/mongolia-annuls-forex-regulation-to-pave-way-forimf-bailout-idUSKBN1810TF> (December 17, 2018.)

<sup>17</sup> BrettonWoods Project 2019, at <https://www.brettonwoodsproject.org/2019/02/the-imf-and-gender-equality-operationalising-change/>, p.8

<sup>18</sup> <https://ikon.mn/n/1din> (June10, 2020)

Дараагийн томоохон дуулиантай тохиолдол нь ураны хайгуул, олборлолтын нөлөөлөлд өртсөн Дорноговь аймгийн Улаанбадрах сум юм. Энэ нутгийн иргэд уул уурхайн үйл ажиллагааны улмаас хүний болон малын эрүүл мэндэд ихээхэн хохирол учирч байгааг, тэр дундаа хүүхдүүд ч, малын үр төл ч төрөлхийн гажигтай төрөх явдал нэмэгдсэн тухай мэдээлж ирсэн. Гэвч засгийн газар, тэр дундаа Эрүүл мэндийн яам, өмнөх шигээ үл тоомсорлож, гомдлын мөрөөр судалж, сөрөг нөлөөллийг бууруулах, цаашид урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваагүй. Засгийн газрын энэхүү байдал улс даяар уул уурхайд нэрвэгдсэн нутгийн иргэдийн бухимдлыг даамжруулж ирлээ.

Энэ илтгэлд Оюу Толгой төслийн зэсийн уурхайн сөрөг нөлөөлөлд өртсөн Ханбогд сум, нүүрсний зургаан уурхайн үйл ажиллагаанд нэрвэгдсэн Гурвантэс сумын иргэдийн гомдол, мэдээллийг тусгалаа. Энэ хоёр сум хоёулаа Өмнөговь аймгийн говийн бүсэд оршдог. Иргэдийн мэдээлэл, гомдлыг нутгийн активистуудын боловсруулсан асуумж ашиглан цуглуулсан.

Уул уурхай нь эмэгтэйчүүдэд, тэр дундаа эмэгтэйчүүдийн эрүүл мэндэд хэрхэн нөлөөлдгийг олон оронд хийсэн судалгаануудаар тогтоосон<sup>19</sup> байдаг. Эдгээр судалгаагаанд ундны усны чанар ба хүртээмж муудах, уул уурхайтай холбоотой орчны бохирдол, тэр дундаа тоосжилтоос үүдсэн агаарын бохирдолтой холбоотой эрүүл мэндийн асуудлууд, мөн эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж хязгаарлагдмал байх зэрэг хүндрэлүүд жагсаагддаг. Уул уурхайн үйл ажиллагаа эмэгтэйчүүдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлдөг тухай шинжлэх ухааны нотолгоо олон улсад ийнхүү хангалттай байсаар атал Монголын засгийн газар өнөөг хүртэл уул уурхайд нэрвэгдсэн газар нутгийн иргэдийн эрүүл мэндийн байдлыг үнэлэх, хамгалаах ямар нэгэн арга хэмжээ авахаас цааргалсаар ирлээ. Ийм нөхцөлд нутгийн эмэгтэйчүүд өөрсдөө санаачлан, тэдний санааг зовниулж буй асуудлуудаар бусад оршин суугчид ямар санаа бодолтой байгааг тодруулах зорилгоор нутгийнхныхаа дунд энэхүү асуумжийг явуулж судаллаа.

Судалгаа явуулсан сум бүрт нутгийн активистууд нүүдэлчин, хагас нүүдэлчин иргэд дундаас наад зах нь 100 хүнээс эрүүл мэндийн товч асуумжаа авахыг зорьсон. Гурвантэс суманд хэвлэмэл асуумжаар иргэдийн санал, гомдлыг цуглуулж, эдгээр асуумжаа Улаанбаатар луу илгээж, мэдээллийг компьютерт гараар шивж оруулсан. Ханбогдод интернетэд суурилсан асуумжаар мэдээлэл цуглуулсан. Асуумжийн зорилго нь уул уурхайн үйл ажиллагаа эхэлснээс хойш тухайн газар нутагт эрүүл мэндийн шинэ асуудлууд гарч эхэлсэн ба эрүүл мэндийн асуудлууд хүндэрч эхэлсэн гэх ажиглалттай нутгийн иргэд хэр санал нийлэхийг тодорхойлоход оршсон. Дашрамд дурдахад, цуглуулсан мэдээллийн дүн шинжилгээний бүрэн тайланг удахгүй Англи хэл дээр гаргах болно. Улаанбадрахад хэвлэмэл асуумжаар авах судалгаа айлаас айл хэсэн авч, мэдээллээ гар аргаар шивэж оруулах болон КОВИД-19-той холбоотойгоор хойшлогдсон болно.<sup>20</sup>

Судалгаанд оролцсон нэгэн иргэний хариулт эдгээр нутгийн иргэдээс бидний түгээмэл сонсдог санааг ийнхүү нэгтгэн илтгэсэн: “Би энэ нутагт бүх насаараа амьдарсан. Сүүлийн үед шинэ хүмүүс ирээд, урьд өмнө үзэгдэж байгаагүй гэмт хэрэг, шинэ өвчин ч гарах боллоо. Суурь шалтгааныг нь судлахгүйгээр зүгээр л эмнэлэг, цагдаагийн хүчин чадлыг нэмээд үр дүн гарахгүй л байна.”

Бид иргэдийн эрүүл мэндийн тухай хариултуудыг сум тус бүрээр нь харуулж байна. Доор танилцуулж буй тоо баримт урьдчилсан дүн шинжигээний үр дүн боловч ерөнхий хандлагыг


---

<sup>19</sup> Jenkins, Katie (2014) Women, mining and development: An emerging research agenda. *The Extractive Industries and Society* 1: 329–339, <https://www.oxfam.org.au/wp-content/uploads/2011/11/OAus-TunnelVisionWomenMining-1102.pdf> and <http://apwld.org/wp-content/uploads/2018/10/Women-and-Mining-in-Asia1.pdf>

<sup>20</sup> Mobile communication quality in Ulaanbadrakh is too slow to use the web-based survey. Paper surveys need to be sent, collected and manually entered which will delay final outcome by at least a month.

тодорхой илтгэж байгаа. Бид судалгааны тайлангаа эцэслэхдээ илүү гүнзгийрүүлсэн дүн шинжилгээний дүнг толилуулах болно.

Ханбогдын судалгаанд оролцогсад (1-р схем) хамгийн их тулгамдсан гурван асуудал гэдэгт нөхөн үржихүйн эрүүл мэнд, ерөнхий эрүүл мэнд, мөн гэр бүлийн гишүүдийн хоорондох харилцааг онцолсон (шар өнгөтэй багана). Судалгаанд оролцогсдын 60 хувь нь эмэгтэйчүүд, 80.19 хувь нь нөхөн үржихүйн насны иргэд байсан. Тавдугаар сарын сүүлчээр хэвлэмэл асуумжаар судалгаа авч эхэлсэн боловч зам тээврийн бэрхшээлээс болон, мөн интернетийн давуу талыг ашиглан 6 дугаар сард нэг долоо хоногийн турш гар утсаар судалгаа авч, Оюу Толгой төслийн нөлөөлөлд өртсөн нутгийн 100 иргэнээс мэдээлэл цуглуулсан. Ханбогдын Эрүүл мэндийн товч асуумжинд хариулахад дундажааар 3.6 минут зарцуулахуйц, 18 эрүүл мэндтэй холбоотой асуултаас бүрдсэн байсан тул гар утасны апп-аар дамжуулан авах боломжтой байсан.




Схем 1. Ханбогдын судалгаанд оролцогсдын уул уурхайн гэр бүлд үзүүлэх нөлөөллийн тухай хариултууд: ногоон – эерэг нөлөөтэй, цэнхэр – нөлөөгүй, шар – сөрөг нөлөөтэй.

Гурвантэс сумын судалгаанд оролцогсдын дийлэнх нь (79 хувиас дээш) эрүүл мэндийн асуудлууд шинээр үүссэн бөгөөд улам даамжирч буй гэдэгтэй санал нийлсэн. Тэдний 63.92 хувь нь эмэгтэйчүүд, 45.56 хувь нь нөхөн үржихүйн насныхан байсан. Гурвантэсийн судалгааг 4 дүгээр сард нэг сарын турш хэвлэмэл асуумж ашиглан, өөр өөр уурхай ба/буюу уурхайн дэд бүтцийн нөлөөлөлд өртсөн таван багийн иргэдийн дунд, байгаль орчин, эрүүл мэнд, шилжин



суурьшилт, амжиргааны эх үүсвэрийн хувьд ялгаатай үр дагавар байгаа эсэхийг тодруулах зорилгоор явуулсан.



Схем 2. Гурван Тэс сумын судалгаанд оролцогсдын “Эдгээр нөхцөл байдлын аль нь өмнө байсан, аль нь шинээр үүссэн бэ?” гэх асуултын хариултууд тухайн нутагт уул уурхайн үйл ажиллагаа эхэлснээс хойш эрүүл мэнд муудаж эхэлсэн гэдэгтэй санал нийлж буйг харуулж байна. Ногоон – өмнө байсан, Цэнхэр – одоогийн байдал.

**Эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн үнэлгээг хийлгэх тухай үндэсний болон олон улсын үүрэг амлалтыг хэрэгжүүлэх улс төрийн зориг дутаж байна**

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд (2012) өндөр эрсдэлтэй төслүүдийн тохиолдолд эрүүл мэндийн үнэлгээ хийх тухай заалт байдаг ч түүнийг өнөөг хүртэл хэрэгжүүлээгүй. Аливаа бодлогын шийдвэр, хөгжлийн хөтөлбөр нь эмэгтэйчүүдийн эрүүл мэнд, ялангуяа нөхөн үржихүйн эрүүл мэндэд хэрхэн нөлөөлж болзошгүйг үнэлэх тухай заасан Конвенцийн 12-р зүйлтэй Монголын засгийн газрын үйл ажиллагаа зөрчилдөж буйг өмнөх илтгэлүүдэд дурдаагүй бөгөөд Байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн үнэлгээний тухай хуульд (2012) өндөр эрсдэлтэй төслүүдийн жендэрийн ялгаатай нөлөөлөл, охид, эмэгтэйчүүдэд учруулах авул, эрсдлийг үнэлэх тодорхой арга хэмжээ багтаагүй.

## Эрүүл мэндийн эрсдлийн тухай мэдээллийг нийтэд дэлгэхгүй байгаа байдал

Төв суурин газрууд дахь нүүрсний хэрэглээтэй холбоотой агаарын бохирдол, бусад хортой бодисын ялгарал, асгаралт зэрэг уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой эрүүл мэндийн эрсдэл, сөрөг нөлөөллийн тухай мэдээллийг улс дотроо мэдээлэхгүй байгаад зогсохгүй, Монголын засгийн газар уул уурхайн хүний эрүүл мэндэд үзүүлдэг сөрөг нөлөөллийн тухай олон улсын бодит жишээ баримт, шинжлэх ухааны үндэстэй судалгааны нотолгоонуудыг өөрийн шинжлэх ухааны судалгаа, тоо баримттай болтол хүлээн зөвшөөрөхгүй байсаар байна. 2016 онд НҮБ-ын Хүүхдийн Сангаас дулааны нүүрсний хэрэглээнээс улбаатай агаарын бохирдол, ялангуяа Улаанбаатар хотын агаарын бохирдол нь монголын эх, хүүхдийн эрүүл мэндэд ямар уршигтай байгаа тухай тайлан гаргасан.<sup>21</sup> Гэвч арга хэмжээ авахгүй байсаар олон хүний амь нас, эрүүл мэнд хохирч, улмаар Утааны эсрэг ээж аавууд хөдөлгөөн өрнөж,<sup>22</sup> засгийн газрыг арга хэмжээ авахыг шаардаж төв талбайд жагсаал цуглаан далайцтай ба давтамжтай өрнүүлснээр Засгийн газраас 2018 оны сүүл, 2019 оны эхэн үе хүргэж байж бодитой арга хэмжээ авсан. Мэдээлэл түгээхгүй байгаа нь иргэдийн эрүүл мэндээ хамгаалах ухаалаг сонголт хийх боломжийг үгүйсгэж байгаа хамгийн гол хүчин зүйлсийн нэг нь мөн. МУ-ын Засгийн газар алт, нүүрс, ураны олборлолтын эрүүл мэндийн сөрөг нөлөөллийн тухай дэлхийн олон оронд хийгдсэн шинжлэх ухааны нотолгоог хүн амынхаа эрүүл мэндийг, ялангуяа нөхөн үржихүйн эрүүл мэндийг хамгаалах, тэднийг мэдээллээр хангах, сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэхэд огт ашиглахгүй байна.

Конвенцын хорооны 76 дугаар хуралдаанд тавьсан Монгол улсын ээлжит тайландаа “**Үндэсний эх, хүүхдийн эрүүл мэндийн 2017-2021 оны хөтөлбөрийн хүрээнд гаргасан ахиц амжилт, мониторингийн дүн**” нэртэй хэсэгт үндэсний эрүүл мэндийн статистикийн мэдээнд “төрөлхийн гажиг, ургийн гажуудал, хромосомын өөрчлөлт” (*congenital malformations, deformations and chromosomal abnormalities*) гэж томъёолсон тохиолдлууд өсөх хандлагатай байгаа тухай огт дурдаагүй байна.<sup>23</sup> Эдгээр статистикийн дагуу төрөлхийн гажиг, ургийн гажуудал, хромосомын өөрчлөлтийн түвшин 1999 онд 3.8 байснаа 2003 онд 7.9 хувьд хүрч хоёр дахин нэмэгдсэн байна. Энэ үзүүлэлт тогтмол өссөөр, 2018 оны хүүхдийн эндэгдлийн статистикийн мэдээнд 0-1 насандаа эндсэн хүүхдүүдийн 16.6 хувь нь төрөлхийн гажиг, ургийн гажуудал, хромосомын өөрчлөлтийн улмаас эндсэн гэж мэдээлсэн. Энэ нь хүүхдийн эндэгдлийн 2 дахь гол шалтгаан бөгөөд хамгийн том шалтгаан нь “жирэмсний дунд ба сүүл үе, төрсний дараах 7 хоногт үүссэн (тодорхой бус) нөхцөл байдал” хэмээн томъёолсон тохиолдолд нь 55.3 хувь-д хүрсэн гэжээ.<sup>24</sup>

Эх, хүүхдийн эрүүл мэндийн сумдаар ялгасан мэдээлэл зөвхөн 2018 оны статистикийн эмхтгэлд багтсан байна. Үүнд сумдын эрүүл мэндийн үйлчилгээний байгууллагууд, хүний нөөц, авах боломжтой үйлчилгээ зэргийн тухай мэдээлэл нилээд дэлгэрэнгүй туссан.<sup>25</sup> Харин эх, нялхсын эндэгдлийн тухай аймаг, сумдаар ялгасан мэдээлэл дутуу байна. Уул уурхайн томоохон үйл ажиллагаатай Дорноговь, Өмнөговь зэрэг аймгууд дахь нас баралт, өвчлөлийн тухай мэдээлэл илүүтэй бүрхэг байна.<sup>26</sup>

Конвенцийн эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн эрхийн тухай 12-р зүйлийг тайлбарласан **24 дүгээр Ерөнхий зөвлөмжийн** 9 дүгээр абзацад гишүүн орнууд эмэгтэйчүүдэд чиглэсэн эрүүл мэндийн хууль тогтоомж, бодлого, төлөвлөгөөнийхөө тухай эмэгтэйчүүдийн дунд хамгийн түгээмэл өвчлөл, тэдний эрүүл мэндэд эрсдэл учруулдаг гол шалтгаануудыг тохиолдлын тоо, тархалт,

<sup>21</sup> [https://www.unicef.org/mongolia/media/911/file/Agariin\\_bohirdol\\_report\\_mn.pdf](https://www.unicef.org/mongolia/media/911/file/Agariin_bohirdol_report_mn.pdf)

<sup>22</sup> <http://www.mglnews.mn/content/read/69702/Ard-irged-utaanii-esreg-jagsaj-baina.htm>

<sup>23</sup> <https://www.chd.mohs.mn/images/pdf/sma/uzuulelt/EnglishM2003.pdf> (энд нас баралтын шалтгааны тухай мэдээллийг зөвхөн 1999 оноос буюу Алт 1 хөтөлбөр хэрэгжиж дуусаны дараах үеэс мэдээлсэн байна)

<sup>24</sup> <https://www.chd.mohs.mn/2019/sariin%20medee/2018eng.pdf> 186 дугаар нүүр

<sup>25</sup> <https://www.chd.mohs.mn/2019/sariin%20medee/2018eng.pdf> 146-154 дүгээр нүүр

<sup>26</sup> Мөн тэнд, 143-144 дүгээр нүүр

эрсдлийн түвшин болон хүйсээр ялгасан найдвартай тоо баримттайгаар тайлагнаж, эрүүл мэндийн хууль тогтоомж, бодлого, төлөвлөгөөнүүд нь шинжлэх ухааны бөгөөд ёс зүйтэй судалгаа, эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн нөхцөл байдал, хэрэгцээний үнэлгээнд суурилж буйг харуулах ёстой гэж тэмдэглэсний дагуу бид дараах арга хэмжээг зөвлөж байна:

- Засгийн газар уул уурхайн нөлөөлөлд өртсөн бүс нутагт, ялангуяа уул уурхайн үйл ажиллагааны улмаас эрүүл мэндээрээ хохирч буйгаа удаа дараа мэдээлж ирсэн ч хангалттай хариу авч чадахгүй хэвээр буй Дорноговийн Улаанбадрах, Өмнөговийн Ханбогд, Гурвантэс сумдад хараат бус шинжээчдээр эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээг жендэрээр ялгасан тоо баримттайгаар хийлгэх хэрэгтэй.
- Нутгийн иргэдийн эрүүл мэндэд уул уурхай болон түүнтэй холбоотой бизнесийн үйл ажиллагаа сөргөөр нөлөөлснөөс үүдсэн хохирлыг барагдуулах, нөхөн төлбөр хийх жендэрийн мэдрэмжтэй стандарт боловсруулж мөрдүүлэх хэрэгтэй.
- Эрдэс, химийн хорт бодис, бусад аюултай материал нь хүний болон малын эрүүл мэндэд хэрхэн сөргөөр нөлөөлдөг талаар нийтийн эрүүл мэндийн сэрэмжлүүлэг, мэдээллийн үйлчилгээ бий болгох хэрэгтэй.

## ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ХУВЬЧЛАЛ

Олборлох салбар, ялангуяа үндэстэн дамнасан томоохон корпорациуд, хөрөнгө оруулагчид өөрсдөдөө таатай хөрөнгө оруулалтын орчинг шаарддаг бөгөөд үүний нэг хэсэг нь тэдэнд болон ажилтнуудад нь шаардлагатай чанартай үйлчилгээнүүд юм. Үүний үр дагаварт, Монголд уул уурхайн ашгаас хүртэж буй, уул уурхайн компанийнхан, тэдний ханган нийлүүлэгчид, дэд бүтэцийн төсөл хэрэгжүүлэгчид зэрэг төлбөрийн өндөр чадвартай үйлчлүүлэгчдэд зориулсан СОС Медика Монголиа Интэрнэшнл,<sup>27</sup> Интермед Монголиа<sup>28</sup> (одоо UFIN) зэрэг үнэтэй, хувийн эмнэлгүүд олон улсын санхүүгийн байгууллагуудын дэмжлэгтэйгээр бий болсон.

Олон улсын санхүүгийн байгууллагуудын төслүүд нь эрүүл мэндийн хувийн салбарыг хөгжүүлэхэд шаардагдах засаглал, стандартчилал зэргийг сайжруулах техникийн туслалцаа үзүүлэхэд чийглэдэг тул улсын эмнэлгүүд тэдний дэмжлэгээс хүртдэггүй. Монголын нийтийн эрүүл мэндийн тогтолцоо нурж байхад олон улсын санхүүгийн байгууллагуудын дэмжлэгтэйгээр хувийн эрүүл мэндийн салбар татвар төлөгчдийн зардлаар цэцэглэж байна. Энэхүү тайланд эдгээр хувийн хэвшлийн эмнэлэгийн үйлчилгээ нь уурхайн нөлөөлөд өртсөн нутгийнхан эсвэл нийтлэг эмзэг бүлгүүдэд хүртээмжтэй, үнэ өртөгийн хувьд боломжтой болон үр өгөөжтэй эсэхийг хэмжиж судлах зорилго тавиагүй болно .

Монгол улс дөнгөж 3.2 сая хүн амтай жижиг улс. Монголын бүх засгийн газар, одоогийн эрх баригчид мөн адил, хүн амаа өсгөх маргаантай бодлогыг хэрэгжүүлж ирсэн. Үндэсний хөгжлийн бодлогод хүн амаа өсгөх нь ажиллах хүчнээ нэмэгдүүлэх арга зам гэж үздэг бөгөөд хөгжлийн хандивлагч байгууллага бүрийн шахам Монголын хөгжлийн боломжуудын тухай тайланд хүн амаа өсгөх зорилгыг зах зээлээ тэлэхтэй холбон дурдсан байдаг. Энэ бүгд нь залуу эмэгтэйчүүдийг олон хүүхэд төрүүлэхийг урамшуулах зорилготой багахан төлбөр, тэтгэмжүүдийн тогтолцоо үүсэхэд хүргэсэн. Гэвч уул уурхайд ажиллаж буй, мөн уул уурхайн

<sup>27</sup> We serve: mining and energy, embassies, international schools, international banks and financial institutions  
[http://www.sosmedica.mn/page\\_list/about\\_us](http://www.sosmedica.mn/page_list/about_us)

<sup>28</sup> <https://www.intermed.mn/eng/>

нөлөөлөлд өртсөн газар нутагт амьдарч буй залуу эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэндийг хамгаалахад чиглэсэн арга хэмжээ авахгүй байсаар байна.

Эх, нялхсын эрүүл мэндийн том төвийг социализмын үед Оросууд барьж өгсөн бөгөөд энэ нь одоог хүртэл эх, нялхсын эрүүл мэндэд тулгарч буй асуудлуудыг шийдвэрлэх техникийн мэдлэг, ур чадвар бүхий, оршин суугаа хаяг, нийгмийн статус, эдийн засгийн чадамжаас үл хамааран хүн бүрт үйлчилдэг цорын ганц төв хэвээр байна. 2020 оны 4 дүгээр сарын 18-нд нэгэн залуу хөгжимчин энэ төвийн фото зурагнуудыг Фэйсбук дээрээ тавьсан нь (Зураг 1)<sup>29</sup> улс орны маань ирээдүй, хойч үеийн эрүүл мэндийг хамгаалах үүрэгтэй улсын байгууллагуудын мөнөөх л цөхөрмөөр нөхцөл байдалд хэвлэл мэдээллийнхэн, олон нийтийн анхаарлыг дахин хандуулсан.



Зураг 1. Эх, нялхсын эрүүл мэндийн үндэсний төвийн Хүүхдийн эмнэлгийн эргэлтийн үүд. Уг төвийн Фэйсбукийн хуудсан дээр энэ үүдийг холоос авсан, илүү цэмцгэр харагдуулсан зураг бий.<sup>30</sup>

Улсын эмнэлгүүд ханиад, томууны улирлаар хүнд өвчтэй хүүхэд, насанд хүрэгчдийг хэвтүүлж эмчлүүлэх шаардлагатай тулгардаг бөгөөд энэ үеэр эмнэлгүүдийн даац хэтэрдэг.

<sup>29</sup> <https://news.zindaa.mn/372m>

<sup>30</sup> <https://www.ehemut.mn/index.php/news/timelist>



Зураг 2. Хүүхдийн эмнэлгийн ор хүрэлцэхгүй, эхчүүд, хүүхдүүд эмнэлгийн коридорт газар унтаж эмчлүүлэх явдал дор хаяад арван жил үргэлжиллээ. Энэ зургийг 2020 оны 1 дүгээр сард Засгийн газрын мэдээ сонинд хэвлэгдсэн нийтлэлээс авав.<sup>31</sup>

**СОС Медика Монголиа** – 2000-аад оны эхээр уул уурхайн томоохон компаниуд Монголд үйл ажиллагаагаа эхлүүлэхэд, дипломат байгууллагууд ба олон улын санхүүгийн байгууллагуудын дэмжлэгтэйгээр тэдгээрт үйлчлэх зорилготой байгуулагдсан анхны хувийн эмнэлгүүдийн нэг. СОС Медика Монголиа нь Улаанбаатар хотын чинээлэг дүргүүдэд байрлах хэд хэдэн салбартай бөгөөд тэдний үйлчлүүлэгч уул уурхайн нөлөөлөлд өртсөн нутгийн иргэдийн эрүүл мэндийг хамгаалах ямар ч үүрэг хариуцлага хүлээдэггүй. Жигээлбэл, СОС Медика Монголиагийн эвакуацийн үйлчилгээ нь зөвхөн нийслэлд үзүүлдэг нарийн мэргэжлийн эмнэлгийн туслалцааг яаралтай авах шаардлагатай жирэмсэн малчин эмэгтэйчүүдэд хүртээмжгүй. Эрүүл мэндийн хүнд байдалтай эмэгтэйчүүд Гурвантэс, Ханбогд, Улаанбадрах зэрэг сумдаас Улаанбаатар хот руу машинаар нэг талдаа 500 – 780 км явж хүрдэг.

<sup>31</sup> <https://zgm.mn/%D0%B8%D1%87%D0%BC%D1%8D%D1%8D%D1%80-%D0%BC%D0%BE%D0%BD%D0%B3%D0%BE%D0%BB%D1%8B%D0%BD-%D1%85%D2%AF%D2%AF%D1%85%D0%B4%D2%AF%D2%AF%D0%B4-%D1%88%D0%B0%D0%BB%D0%B0%D0%BD-%D0%B4%D1%8D%D1%8D%D1%80-%D1%8D%D0%BC%D1%87%D0%BB%D2%AF%D2%AF%D0%BB%D0%B6-%D0%B1%D0%B0%D0%B9%D0%BD%D0%B0/>



Зураг 2. СОС Медика Монголиа – төв байр.

Тэдний үйлчлүүлэгчид нь:<sup>32</sup>

- Уул уурхай, эрчим хүчний байгууллагууд
- Элчин сайдын яамд
- Олон улсын сургуулиуд
- Төрийн бус байгууллагууд
- Олон улсын банк, санхүүгийн байгууллагууд

**Интермед Монголиа буюу Юнайтед Фэмили Интермед Эмнэлэг (УФИИ)** – Уул уурхай, эрчим хүчний салбарт үйл ажиллагаа бүхий томоохон хувийн корпораци болох Эм Си Эс Групп, (ЕСБХБ-ны санхүүжилттэй) нүүрс олборлогч Энержи Ресурс болон шатахуун түгээгч томоохон компани болох Шунхлай группын эзэмшлийн энэхүү эмнэлгийг Олон улсын санхүүгийн корпорациас санхүүжүүлсэн. Мөн дахин л нийт иргэдийн бус, том бизнесүүд болон хувийн эмнэлгийн өндөр үнийг төлөх чадвартай нийгмийн бүлгийн эрх ашигт үйлчилж, стандарт хангасан онош, эмчилгээ авахын тулд байгаа бүхнээ зориулахаас өөр аргагүй болсон иргэдийн халаасыг хоослох, төлбөрийн чадваргүй иргэдийг гадна үлдээх бодлого хэрэгжсэний тод жишээ энэ.

---

<sup>32</sup> [http://www.sosmedica.mn/page\\_list/about\\_us](http://www.sosmedica.mn/page_list/about_us)



Байгаа судалгааны нотолгооноос харахад хувийн эмнэлгийн салбар нь уул уурхайн нөлөөлөлд өртсөн газар нутгийн иргэдийн дийлэнхэд хүртээмжгүй байна. Үүнтэй холбоотойгоор, Гадаад өрийн асуудлаарх НҮБ-ын Тусгай илтгэгчийн дараах зөвлөмжийг бид дэмжиж байна:

- Олон улсын санхүүгийн байгууллагууд нийтийн эрүүл мэндийн үйлчилгээний газруудыг сайжруулахад, ялангуяа эх, нялхсын эрүүл мэндийн төвүүдийг сайжруулах болон ийм төвүүдийг аймгийн төвүүдэд байгуулахад чиглэсэн тэтгэлэг олгох нь зүйтэй.
- “Олон улсын санхүүгийн байгууллагууд орлого багатай орнуудын нийгмийн үйлчилгээг сайжруулах, хүнсний тусгаар тогтнолыг нь хангах зорилгоор зээл биш, төслийн тэтгэлэг өгөх хэрэгтэй. Энэ нь хүнс тэжээлийн дутагдлаас сэргийлэх, ядуурлыг бууруулахад хувь нэмрээ оруулна.”<sup>33</sup>

Мөн томууны улирал зэрэг нийтийг хамарсан бусад халдварт өвчний тархалтын үед хувийн эмнэлгүүд улсын эмнэлгийн жишиг үнээр үйлчлэх зохицуулалтыг Засгийн газраас нэвтрүүлж хэрэгжүүлэх хэрэгтэй.

---

<sup>33</sup> Zuckerman, E. 2018, A Guide to Women’s Rights and Environmental Justice Advocacy on International Financial Institutions, at <https://www.bothends.org/en/Whats-new/Publicaties/A-Guide-to-Womens-Rights-and-Environmental-Justice-Advocacy-on-International-Financial-Institutions/> (June 10, 2020).